



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/ВЗ38

Улаанбаатар хот

Хяналт шалгалт зохион байгуулж
явуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.8, 30.1.16, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 107 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар нэгжийн 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд зохион байгуулах хяналт шалгалтыг 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс хойд бүсийн Онцгой байдлын газар /Архангай, Булган, Дархан, Сэлэнгэ, Төв, Орхон, Хөвсгөл/-т, 11 дүгээр сарын 09-ний өдрөөс баруун бүсийн Онцгой байдлын газар /Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд, Завхан/-т, 11 дүгээр сарын 14-ний өдрөөс өмнөд бүсийн Онцгой байдлын газар /Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь/-т 11 дүгээр сарын 15-ны өдрөөс Улаанбаатар бүсэд, 11 дүгээр сарын 19-ний өдрөөс зүүн бүсийн Онцгой байдлын газар /Дорнод, Сүхбаатар, Хэнтий/-т тус тус эхлүүлж 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж явуулсугай.

2. Хяналт шалгалт явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналт шалгалтын удирдамжийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хяналт шалгалтад хамрагдах бэлтгэл бэлэн байдал болон аюулгүй байдлыг хангуулж, бие бүрэлдэхүүнийг бүрэн хамруулахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

4. "Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам"-ыг хэрэгжүүлэх шалгалтын дүнг нэгтгэн, холбогдох саналыг танилцуулж, шийдвэрлүүлэхийг Захиргааны удирдлагын газар (хурандаа Л.Болдбаатар), Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар (дэд хурандаа Я.Гантөмөр)-т тус тус даалгасугай.

00002995

5. Ажлын хэсгийн томилолт, шатахууны зардалд нийт [REDACTED]

[REDACTED] төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар (дэд хурандаа Я.Гантөмөр)-т зөвшөөрсүгэй.

6. Хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, дүнг 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (хурандаа Г.Бат-Эрдэнэ, хурандаа Ц.Нямбаяр, хурандаа Л.Өлзийбаяр, дэд хурандаа Я.Гантөмөр, дэд хурандаа Д.Баасансүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ